

**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан.

Улмаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/316 дугаар захирамжаар тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийг баталж, орон тоог тогтоосон.

Захирамжийн дагуу байгууллага нь Техник, технологийн алба; Захиргаа, хүний нөөцийн алба; Санхүү, эдийн засгийн алба гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хугацаанд дор дурдсан арга хэмжээг авч ажиллаж байна:

Байгууллага шинээр байгуулагдсантай холбогдуулан ажилтнуудын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтыг баталж, албан тушаалын үндсэн цалинг тогтоон, албан тушаалд томилж, Хөдөлмөрийн гэрээг байгуулав.

Мөн ажилтнуудын хувийн хэргийн бүрдлийг тухай бүр хангуулж байна.

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг, 2 дугаар хавсралтаар Цалин хөлсний журмыг, мөн өдрийн А/13 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу газрын дарга, албаны дарга, нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд мэдүүлэв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дагалдан гарсан эрх зүйн бусад баримт бичгийн үйлчлэлд байгууллагын удирдах албан тушаалтнууд хамаарч байгаа тул ажилтны ёс зүйн дүрмийн төслийг боловсруулж, саналыг авч байна.

Мөн байгууллагын хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын төслийг боловсруулж, ажилтнуудын саналыг авч байна.

Өнгөрсөн хугацаанд ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд дараах сургалтад хамруулаад байна:

1. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран зохион байгуулсан [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) мэдээллийн системийг таниулах, албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 1 ажилтан хамрагдав.

2. 2025 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” НҮТББ-аас зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх цахим сургалтад холбогдох 3 ажилтан хамрагдаж, амжилттай суралцав.

3. 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан Архив, албан хөтлөлтийн тухай сургалтад архив, бичиг хэргийн мэргэжилтэн хамрагдав.

4. 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монголын Уул уурхайн үндэсний ассоциациас хамтран зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын инженер хамрагдав.

5. 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс хамтран зохион байгуулсан “Ахисан түвшний аюулын хяналт, Европын холбооны сайн туршлага” сэдэвт сургалтад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын инженер хамрагдав.

6. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилтнуудыг холбогдох сургалтад тухай бүр хамруулж байна.

Түүнчлэн ажилтнуудын дунд мэдээлэл хуваалцах зорилго бүхий Мэдээллийн цагийн эхний удаагийн сургалтыг зохион байгуулаад байна.

Ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжөөр тухай бүр ханган ажиллаж байна.

**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

2025.06.24